

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

---

2008 оны 3 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

“Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХЯНАЛТ ТАВИХ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.4 дэх заалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч (цаашид “даатгалын байгууллага” гэх)-ийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөхөд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Зайнаас тавих хяналт (цаашид “хяналт” гэх)-ын зорилго нь даатгалын байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээ, хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээлэлд үндэслэн даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, үүсч болзошгүй санхүүгийн эрсдэлийн түвшинг тогтоох, алдаа зөрчилтэй асуудлыг илрүүлж санхүүгийн хүндрэл бэрхшээлээс урьдчилан сэргийлэхэд чигэлсэн шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх санал дүгнэлт боловсруулан Хорооны удирдлагад танилцуулж, шуурхай шийдвэрлүүлэхэд оршино.

1.3. Даатгалын байгууллагын санхүүгийн байдалд зайнаас тавих хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна:

1.3.1. Санхүүгийн тайлан, бусад тайлан, мэдээнд үндэслэн тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа болон цаашид үүсч болзошгүй санхүүгийн эрсдэлийн түвшинг тогтоох;

1.3.2. Даатгалын байгууллагын санхүүгийн эрсдэлийн түвшинг тогтоосны үндсэн дээр түүний санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

1.3.3. Даатгалын байгууллагын үйл ажиллагааг цаашид хэвийн явуулах арга замыг тодорхойлсон заавар, зөвлөмж өгөх, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахад чигэлсэн үүрэг даалгавар өгч биелэлтийг нь хангуулах.

### **ХОЁР. Хяналт тавих**

Хяналтын зарчим

2.1. Хорооны улсын байцаагч, мэргэжилтэн (цаашид “мэргэжилтэн” гэх) нь Даатгалын газрын даргын баталсан хуваарийн дагуу даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавихдаа даатгалын зах зээлийн эрх зүйн зохицуулалтын талаар гарсан хууль тогтоомж, Хорооны баталсан дүрэм, журам, заавар, олон улсын стандартыг мөрдөж ажиллана.

2.2. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж ажиллахдаа бие даасан, шударга байх зарчмыг баримтлахын хамт Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг чанд сахиж биелүүлнэ.

2.3. Мэргэжилтэн нь зайнаас хяналт тавьж байгаа даатгалын байгууллагатай аливаа ашиг сонирхолын зөрчилгүй байна.

2.4. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтыг гүйцэтгэхдээ Хорооны дотоод журам, албан тушаалын заавар болон ажил үүргийн хуваарийг нарийвчлан мөрдөж ажиллана.

#### Хяналтад ашиглах тайлан, мэдээ

2.5. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавихдаа тухайн даатгалын байгууллагын санхүүгийн тайлан, мэдээ, тэдгээрт хийсэн тайлбар тодруулга болон бусад холбогдох этгээдүүдээс гаргасан дараах мэдээлэл (цаашид “тайлан, мэдээ” гэх)-ийг ашиглаж үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

2.5.1. Даатгалын байгууллагын холбогдох заавар, журамд заасан санхүүгийн тайлан, мэдээ, тайлбар тодруулгын хамт;

2.5.2. Тухайн даатгалын байгууллагад хийсэн газар дээрх төлөвлөгөөт иж бүрэн болон хэсэгчилсэн, сэдэвчилсэн шалгалтын тайлан, тогтоосон акт, өгсөн үүрэг даалгавар, биелэлтийн тухай танилцуулга, холбогдох бусад материал;

2.5.3. Тухайн даатгалын байгууллагын санхүүгийн тайлан, мэдээг хөндлөнгийн хяналтын байгууллагаас хянаж баталгаажуулсан тухай аудитын тайлан, дүгнэлт, түүний тайлбар;

2.5.4. Дотоод хяналтын алба, нэгжээс боловсруулсан тайлан, мэдээ;

2.5.5. Даатгалын байгууллага анх байгуулагдаж Хорооноос тусгай зөвшөөрөл олгохыг хүсч бүрдүүлж ирүүлсэн баримт материал, түүнд орсон аливаа өөрчлөлтийн талаар тухайн бүрд ирүүлж байсан мэдээлэл;

2.5.6. Бусад мэдээлэл (даатгуулагчдаас гаргасан гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан мэдээ, мэдээлэл, шүүх, хууль хяналтын байгууллагуудын

даатгалын байгууллагатай холбогдуулан гаргасан шийдвэр, тогтоол болон бусад мэдээлэл).

Тайлан, мэдээг хянах

2.6. Мэргэжилтэн нь зөвхөн Хорооны бичиг хэрэгт бүртгүүлсэн тайлан, мэдээ, даатгалын байгууллагатай холбогдсон бусад мэдээлэл, баримт материалыг гарын үсэг зурж хүлээж авна.

2.7. Мэргэжилтэн нь хүлээн авсан тайлан, мэдээг дор дурдсан байдлаар хянаж шалгана. Үүнд:

2.7.1. Тайлан, мэдээ, бусад холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд ирүүлсэн эсэх;

2.7.2. Тайлан, мэдээ, бусад холбогдох мэдээлэл бүрэн гүйцэд байгаа эсэх;

2.7.3. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч болон бусад удирдах ажилтнууд санхүүгийн тайланг үнэн зөв гаргасан гэдгээ баталгаажуулж гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан эсэх;

2.7.4. Тайлан, мэдээний үзүүлэлтүүд “Даатгалын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн бусад журам, заавартай нийцэж байгаа эсэх;

2.7.5. Тайлан, мэдээний үзүүлэлтүүдийн тооцоолол үнэн зөв болсон эсэх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог зөв гаргасан эсэх;

2.7.6. Даатгалын байгууллагын тайлан, мэдээний үзүүлэлтүүд нь өмнөх тайлант үеийнхээс өссөн болон буурсан байдал, үүнд тайлбар хийсэн эсэх;

2.7.7. Тайлант үеийн тоон үзүүлэлтүүд тухай даатгалын байгууллагын үйл ажиллагаанд газар дээр хийсэн шалгалтын акт материалтай тохирч байгаа эсэх (илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдал, даатгалын хэлбэр тус бүрээр даатгалын хураамжийн орлогыг бүртгэсэн болон даатгалын учирч болзошгүй нөөц санг бүрэн байгуулсан зэрэгт үнэлэлт дүгнэлт өгнө).

2.8. Энэ журмын 2.7.2 – 2.7.7-д заасан шаардлагыг хангаагүй тайлан, мэдээг мэргэжилтэн хүлээн авахаас татгалзаж, шаардлага хангасан тайлан, мэдээг яаралтай ирүүлэхийг шаардаж, тухайн даатгалын байгууллагад албан бичгээр хугацаатай үүрэг өгнө.

2.9. Тайлан, мэдээг бүрэн гүйцэд ирүүлээгүй даатгалын байгууллагад зөрчлийн байдлаас хамааруулан даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу шийтгэвэр оногдуулж арга хэмжээг авна.

2.10. Татан буулгах ажлын хэсэг томилогдсон, тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон даатгалын байгууллагад тайлан, мэдээ, судалгааг үндэслэн дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

2.10.1. Тайлан, мэдээнд хамрах хугацаанд хийгдсэн буюу дуусаагүй даатгалын гэрээнүүдийг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг гэрээ тус бүрээр тулгаж үзнэ;

2.10.2. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас холбогдох судалгааг авч, харьцуулалт хийж дүгнэлт гаргана.

#### Хяналтын үйл ажиллагаа

2.11. Даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг даатгалын хэлбэр тус бүрээр хянаж, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд газар дээр хийсэн шалгалтын тайлантай харьцуулан дүгнэлт хийнэ, нийт даатгалын хураамжийн орлого нь даатгалын байгууллагын санхүүгийн тайлан тэнцлийн дүнтэй тохирч байгаа эсэхийг шалгана.

2.12. Санхүүгийн тайланд залруулга хийхдээ даатгалын байгууллагад эрсдэл учруулж болзошгүй бүх үзүүлэлтүүдийг хянаж дүгнэлт гарган удирдлагад урьдчилж танилцуулна.

2.13. Даатгалын байгууллагын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлан, даатгалын учирч болзошгүй хохирлын нөөц сангийн бүрдэлтийн тайлан, одоо байгаа нөөц сангийн хүрэлцээ буюу их хэмжээний даатгалын нөхөн төлбөрийг түргэн гүйцэтгэх чадварын тайлан, даатгалын эрсдэлийн судалгааны тайлан, даатгалын хураамжийн тайлан, даатгалын байгууллагын мөнгөн хөрөнгө (сангууд)-ийн байршлын тайлан болон бусад шаардлагатай тайланг гаргана.

2.14. Мэргэжилтний тооцоолж гаргасан тайлан, мэдээний үзүүлэлт нь даатгалын байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээний үзүүлэлттэй зөрсөн тохиолдолд мэргэжилтэн нь өөрийн гаргасан тайлан, мэдээний үзүүлэлт тус бүрийн зөрүүний талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, хэрэв даатгалын байгууллагын алдаа байвал энэ тухай тайлангийн хариунд тусгаж, дүгнэлт гарган гарын үсэг зурж баталгаажуулна.

2.15. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихдаа тухайн даатгалын байгууллагын үзүүлэлтүүдийг авч үзэхээс гадна даатгалын хэлбэр, хамрах хүрээний хувьд ижил төстэй бусад даатгалын байгууллагын дундаж үзүүлэлтүүдтэй харьцуулалт хийж үзнэ.

Даатгалын байгууллагын төлбөрийн чадварт үнэлэлт өгөх, эрсдэлийг тооцох

2.16. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавихдаа тухайн даатгалын байгууллагын санхүүгийн чадавхид сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа эрсдэлтэй асуудлыг илрүүлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, ирүүлсэн тайлан, мэдээ, бусад холбогдох мэдээлэлд үндэслэн даатгалын байгууллагын санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт дүгнэлт өгч, Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцно.

2.17. Даатгалын байгууллагын санхүүгийн тайлан тэнцэл, бусад тайлан, мэдээг компьютерын файлд оруулж, нэгдсэн файлын дагуу мэдээллийн товчоо, санхүүгийн үзүүлэлтүүдийн динамик судалгааг гаргаж, цаасан дээрх хувийг тухайн даатгалын байгууллагын хувийн хэрэгт бүртгэж хадгална.

2.18. Дээрх файлын дагуу даатгалын байгууллагын санхүүгийн тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгө (сангууд)-ийн байршил болон санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх тайлант үеийнхээс өөрчлөгдсөн байдал, санхүү, төлбөрийн чадвар болон бусад үзүүлэлтийн хоорондын харьцуулалтыг энэхүү журмын Хавсралт 1, 2, 3, 4-ийг ашиглан тооцоолж, үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

2.18.1. **Дүрмийн сангийн хөрөнгө:** Даатгалын байгууллагын дүрмийн сангийн хөрөнгө нь тухайн даатгалын компанийн үйл ажиллагааны эрсдэл хүлээх гол баталгаа болдог тул уг дүрмийн сангийн бүрдэлт, байршил нь Хорооноос тавьсан нөхцөл шаардлагад хэрхэн нийцэж байгааг Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөцийн сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” болон энэ журмын Хавсралт 1-ийн дагуу гаргаж, үнэлэлт дүгнэлт өгнө;

2.18.2. **Мөнгөн хөрөнгийн байршилт:** Даатгалын байгууллага даатгуулагчдын өмнө гэрээгээр хүлээсэн санхүүгийн үүргээ биелүүлэхийн тулд дүрмийн сан болон даатгалын учирч болзошгүй нөөц санг мөнгөн хөрөнгийн хэлбэрээр хаана яаж байршуулсныг Хавсралт 2-ын дагуу бүртгэн хянаж, улирал бүр дүгнэлт гаргана;

2.18.3. **Төлбөрийн чадварын үзүүлэлт:** Даатгалын байгууллагын санхүүгийн чадавхийг бодитойгоор үнэлэх зорилгоор мэргэжилтэн нь тухайн даатгалын байгууллагын төлбөрийн чадварын үзүүлэлтийн өөрчлөлтөнд Хорооны 2007 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тогтмол хяналт тавьж ажиллана. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг Хавсралт 3-ын дагуу сар, улирлаар тооцож гаргасан динамик судалгаа хийнэ;

2.18.4. *Даатгалын байгууллагын удирдлага:* Даатгалын байгууллагын санхүүгийн төлбөрийн чадвар нь компанийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрээс хамаарах тул бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж байгаа удирдлагын менежментийн чадавхид гаргасан шийдвэр, хэрэгжилтийн үр дүн, туршлага, боловсролын түвшин болон холбогдох бусад мэдээлэлд үндэслэн үнэлэлт өгнө.

2.18.5. *Даатгалын байгууллагын ашигт ажиллагаа:* Даатгалын байгууллагын мөнгөн хөрөнгийн хэмжээ яаралтай төлбөр гүйцэтгэх хангалттай хүрэлцэх түвшинд байгаа эсэх нь компанийн ашигт ажиллагаатай холбоотой тул даатгалын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлага, даатгалын учирч болзошгүй хохирлын нөөц сангийн хэмжээ, ашиг (алдагдал)-тай ажилласан тооцоог энэ журмын Хавсралт 4-ийн дагуу хийж, үнэлэлт дүгнэлт өгнө.

2.19. Мэргэжилтэн даатгалын байгууллагын санхүүгийн тайланд үндэслэн тооцож гаргасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад үзүүлэлтүүдэд үнэлэлт дүгнэлт өгнө. Даатгалын байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг тооцох, даатгалын зах зээлийн өөрчлөлтийн мэдрэмжийг тодорхойлох зорилгоор төрөл бүрийн шинжилгээний аргууд (Stress test, Z-score, Gap analysis)-ыг хэрэглэж, дүгнэлт гаргана.

2.20. Даатгалын байгууллагын дүрмийн сан болон нөөц сангийн мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж төрөл бүрийн үнэт цаас, бонд эзэмшиж байгаа нөхцөлд зах зээлийн эрсдэлийн шинжилгээ болон зээлийн эрсдэлийн шинжилгээг хийнэ.

2.21. Мэргэжилтэн нь төлбөрийн чадварын үзүүлэлт, тохиргоо хийгдсэн хөрөнгийн тооцоолол болон бусад тайлан мэдээнд үндэслэн үйл ажиллагаанд зайнаас тавьсан хяналтын дүгнэлт (цаашид “дүгнэлт” гэх)-ийг улирал бүр бичиж, холбогдох арга хэмжээг хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ. Даатгалын байгууллагын үйл ажиллагаа илт доголдох болсон үед сэдэвчилсэн шалгалт хийх, Хороонд гэнэтийн шалгалт хийхийг хүсч мэдээлэл ирүүлсэн зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдол гарсан тухайн бүрд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийг хугацаа харгалзахгүй бичиж болно.

2.22. Мэргэжилтэн нь зайнаас тавих хяналтын дүгнэлтээс гадна Хорооны 2008 оны ... дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын хувийн хэрэг хөтлөх заавар”-ын дагуу мэдээллийг хагас жил тутам гаргаж хувийн хэрэгт хадгална.

2.23. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон үед татан буулгах үйл ажиллагаа, хууль тогтоомжийн дагуу ямар арга хэмжээ авагдсан талаар мэргэжилтэн танилцуулга бичиж, удирдлагад танилцуулна.

2.24. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох шаардлагатай болсон тохиолдолд уг асуудлыг Хорооны тогтоолоор шийдвэрлүүлэх төсөл боловсруулж, удирдлагад танилцуулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хүргүүлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг даатгалын байгууллагаас гаргуулан авч, уг үйл ажиллагаанд хяналт тавьж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсралтын хамт хураан авч "Хорооны ...оны ...тоот тогтоолоор хүчингүй" гэсэн тэмдэгийг баруун доод өнцөгт 45 градусын налуугаар дарж даатгалын байгууллагын хувийн хэрэгт хадгална.

### **ГУРАВ. Даатгагчийн түүх хөтлөх**

3.1. Даатгалын байгууллагын түүх (цаашид "түүх" гэх)-д даатгалын байгууллага анх байгуулагдаж даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш татан буугдах хүртэлх хугацааны тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг хугацааны дарааллын дагуу бичиж хадгална.

3.2. Даатгалын байгууллагын түүхийг улирлын үечлэлтэйгээр хөтөлнө. Түүх нь дараахь дөрвөн хэсгээс бүрдсэн байна. Үүнд:

3.2.1. Үндсэн мэдээлэлд тухайн даатгалын байгууллага үүсгэн байгуулагдсан (татан буугдсан) огноо, удирдлага, бүтэц зохион байгуулалт зэрэг даатгалын байгууллагын талаарх мэдээллүүдийг тусгана (Үүнд оноосон нэр, хаяг, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл, дүрмийн сангийн хувь хэмжээ, бүтэц, салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл, гарсан өөрчлөлтүүд);

3.2.2. Динамик үзүүлэлтэд тухайн даатгалын байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүд орно (Үүнд даатгалын хураамж, нөхөн төлбөр, учирч болзошгүй хохирлын нөөц сан, үндсэн үйл ажиллагааны зардал, бусад үйл ажиллагааны орлого, зарлага зэрэг);

3.2.3. Даатгалын байгууллагад Хороо болон холбогдох бусад байгууллага (Сангийн яам, ГЕГ, ҮТЕГ зэрэг)-аас авсан арга хэмжээний жагсаалт. Хорооноос авсан арга хэмжээг албадлагын арга хэмжээ, бусад арга хэмжээ гэж 2 хэсэгт хуваана:

- Хорооноос авсан албадлагын арга хэмжээнд улсын байцаагчийн тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэвэр, Хорооны тогтоол, албан бичгээр өгөгдсөн хугацаатай үүрэг даалгавар, шийдвэр орно;

- Бусад арга хэмжээнд уг даатгалын байгууллагад Хорооноос явуулсан бусад албан тоот, шийдвэр орно;



- Холбогдох бусад байгууллагаас авсан арга хэмжээнд даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан бусад байгууллагаас албан тоотоор Хороонд ирүүлсэн арга хэмжээг оруулна.

3.2.4. Даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой онцлог түүхэд тухайн компанитай холбоотой гарсан онцгой мэдээллүүдийг оруулна (Үүнд даатгалын байгууллагын удирдлага, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох гэх мэт).

3.3. Мэргэжилтэн нь жилд 1 удаа дараа жилийн 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор даатгалын байгууллагын түүхийг газрын даргад танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тухайн бүрд танилцуулж чиглэл авна.

3.4. Даатгалын байгууллагын түүхийг нэгтгэл хариуцсан мэргэжилтэн даатгалын байгууллагын түүх агуулсан файлыг жилд нэг удаа архивлан хадгална. Даатгалын байгууллагын түүх нь нууцын ангилалд хамаарах бөгөөд үүнтэй холбоотой харилцааг холбогдох журмаар зохицуулна.

## **ДӨРӨВ. Хяналт хийсэн тухай дүгнэлт, танилцуулга**

### *Зайнаас тавих хяналтын дүгнэлтийг боловсруулах*

4.1. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадварын байдалд зайнаас хяналт тавьж, дүгнэлт гаргахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.1.1. Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварын талаарх дүгнэлт товч тодорхой, ойлгомжтой байна.

4.1.2. Дүгнэлт дараах шаардлагыг бүрэн хангасан байна. Үүнд:

- Энэ журамд заасан бүтцийн дагуу бичигдсэн байх;
- Дүгнэлтийг бүрэн гүйцэд, үнэн зөв бичсэн байх;
- Санхүүгийн хүндрэл үүсч болзошгүй эсэхийг тогтоосон байх;
- Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тусгасан байна (үүрэг даалгаврын биелэлтийг хяналтын явцад дүгнэх боломжгүй бол цаашид авах арга хэмжээний тухай саналыг тусгах).

4.2. Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадварыг илэрхийлсэн үзүүлэлтийн өөрчлөлтийн талаар дүгнэлтэд тодорхой тусгана.

#### Дүгнэлтийн хүрээ

4.3. Дүгнэлтийг улирал, жилийн үйл ажиллагааг хамарсан байдлаар бичнэ. Мөн газар дээрх шалгалт хийхтэй холбогдуулан тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлтээр тусад нь дүгнэлт бичнэ.

4.4. Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналтын болон газар дээрх шалгалт хийхэд зориулан бичих дүгнэлтийг зайнаас хяналт тавих дүгнэлтийн нэгэн адил бичих бөгөөд шаардлагатай зүйлийг нэмж тайлбар бичиж болно.

4.5. Даатгалын байгууллагын зайны дүгнэлтийг тухайн жил, улирлын үйл ажиллагааг хамруулан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, өмнөх улирал, тайлант оны эхэн болон өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн байдал, түүний шалтгааны талаар тусгасан байна. Дүгнэлтэд даатгалын байгууллагын санхүү, төлбөрийн чадварын болон бусад холбогдох үзүүлэлтийн динамик судалгааг графикаар гарган хавсаргана.

4.5. Даатгалын байгууллагын үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын талаарх дүгнэлтийг бичихдээ бусад даатгалын байгууллагатай харьцуулан дүгнэлт хийж болно.

4.6. Тайлант хугацаанд даатгалын байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлтүүдэд огцом өөрчлөлт гараагүй бол уг үзүүлэлтийн талаар дүгнэлтэд дурдахгүй байж болно.

#### Дүгнэлтийн бүтэц

4.7. Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадварын талаарх дүгнэлтийг дараах бүтэцтэйгээр боловсруулж, удирдлагад танилцуулна. Үүнд:

Нэг. Даатгалын байгууллагын үндсэн үзүүлэлтүүдийн хураангуй.

Хоёр. Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн талаарх дүгнэлт.

Гурав. Хууль тогтоомжийн дагуу даатгалын байгууллагад хариуцлага ногдуулах болон цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай санал.

Дөрөв. Даатгалын байгууллагын ашигт ажиллагаа (орлого, зарлага, ашиг, алдагдал).

Тав. Даатгалын байгууллагын өөрийн хөрөнгийн талаар.

Зургаа. Даатгалын нөөц санг байгуулсан байдал.

Долоо. Удирдлага, бүтэц зохион байгуулалт, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтүүд.

Найм. Даатгалын байгууллагад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний товч танилцуулга.

Ес. Хавсралт материал.

4.8. Даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн даатгалын байгууллагын тайлан, мэдээг тайлант хугацааны дараа сарын 20-ны өдрийн дотор дотоод сүлжээгээр авч нэгтгэн, даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүдийн нэгдсэн тайланг гаргана.

4.8.1. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүдийн хураангуйд даатгалын байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийг салбараар болон даатгалын ангилал, төрөл, даатгалын гол хэлбэрүүдээр гаргаж холбогдох тайлбар, дүгнэлтийг хийнэ. Ингэхдээ даатгалын байгууллагын тайлан тэнцэлд ямар тохируулга хийгдсэн тухай тодруулга, тайлбарыг тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж ажилласан мэргэжилтнээр гаргуулж, тус бүрд нь тодорхой тайлбар хийж, дараах үзүүлэлтүүдийн талаар динамик судалгаа гаргаж, график дүрслэлийг нэгдсэн танилцуулгад хавсаргана. Үүнд:

- Даатгалын салбарын ерөнхий үзүүлэлтүүд;
- Даатгалын зах зээлд даатгалын байгууллагуудын эзлэх хувь хэмжээ;
- Даатгалын хураамжийн орлого;
- Даатгалын нөхөн төлбөрийн үзүүлэлтүүд;
- Даатгалын нөөц сангийн бүрдэлтийн байдал;
- Даатгалын салбарын санхүүгийн байдлыг харуулсан бусад үзүүлэлт.

4.8.2. Даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн нь зайнаас хяналт тавьсан мэргэжилтний гаргасан дүгнэлттэй танилцаж, Даатгалын

газрын даргын саналыг авсны үндсэн дээр төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт нь буурах хандлага илэрсэн, санхүүгийн эрсдэл нь нэмэгдэж байгаа болон бусад үзүүлэлтээр онцгой анхаарал татсан даатгалын байгууллагын талаар дараах дүгнэлтийг боловсруулна:

- Тайлант хугацаанд даатгалын байгууллагад гарсан голлох өөрчлөлтүүд (бүтэц, удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлт, санхүүгийн эрсдэлтэй үйл ажиллагааны талаар компанийн удирдлагын гаргасан шийдвэр, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн өөрчлөлт);

- Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдал болон компанийн удирдлагын гаргасан алдаа нь цаашид даатгалын салбарын санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байдал.

4.8.3. Дээрх дүгнэлтийг үндэслэн Даатгалын газрын дарга анхаарал татсан даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал болон үйл ажилагаанд нь хязгаарлалт хийх, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх шаардлагатай даатгалын байгууллагын талаарх танилцуулгыг Хорооны удирдлагад танилцуулна.

4.9. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгож, татан буулгах ажлын хэсэг томилогдсон даатгалын байгууллагын талаарх дүгнэлтийг дараах бүтэцтэйгээр боловсруулна. Үүнд:

4.9.1. Даатгуулагчидтай хийсэн гэрээний үлдэгдэл болон бусад байгууллагатай хийж дуусгах шаардлагатай өглөг, авлагын барагдуулалтын байдал;

4.9.2. Даатгуулагч иргэд, байгууллагын санал хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу Хорооноос авсан арга хэмжээний биелэлт;

4.9.3. Шаардлагатай тохиолдолд цаашид авах арга хэмжээний талаарх санал.

4.10. Дараах тохиолдлуудад даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгож татан буулгах ажлын хэсэг томилогдсон даатгалын байгууллагад тавих хяналтыг дуусгавар болгоно. Үүнд:

4.10.1. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон даатгалын байгууллагыг татан буулгах үйл ажиллагаа явагдаж дууссан;

4.10.2. Даатгалын байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийг даатгалын салбарын нэгдсэн үзүүлэлтүүдээс хасах тухай болон үйл ажиллагаанд нь тавих хяналтыг зогсоох тухай шийдвэр гарсан.

4.11. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон даатгалын байгууллагад хяналт тавих үйл ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд хувийн хэргийг даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн Хорооны архивт шилжүүлнэ.

Зайнаас тавьсан хяналтын дүгнэлт, танилцуулгад тавигдах шаардлага

4.12. Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьсан мэргэжилтэн нь гаргасан дүгнэлтдээ гарын үсэг зурж, хэрэв улсын байцаагч бол улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулан, тохируулга хийсэн тэнцэл, орлого, зарлагын тайлан болон бусад хавсралтын хамтаар улирал бүрийн дараа сарын 25-ны өдрийн дотор Даатгалын газрын даргад танилцуулна.

4.13. Даатгалын газрын дарга нь энэхүү журамд заасны дагуу дүгнэлт бичигдсэн эсэхийг хянаж, дутуу бичигдсэн буюу нэмж тусгах, дэлгэрүүлэх, тодруулах шаардлагатай асуудлын талаар мэргэжилтэнд үүрэг өгч, ажлын 3 хоногийн дотор мэргэжилтэн санал дүгнэлтийг эцэслэн боловсруулна.

4.14. Даатгалын газрын дарга нь дүгнэлтийг шаардлага хангасан гэж үзвэл баталгаажуулан гарын үсэг зурж, даатгалын байгууллагын үзүүлэлтүүдийг даатгалын салбарын нэгтгэлд нэгтгүүлсэн эсэхэд хяналт тавина.

4.15. Мэргэжилтэн нь Даатгалын газрын даргад танилцуулсан дүгнэлтийн нэг хувийг тухайн даатгалын байгууллагын хувийн хэргийн хавтсанд хадгална.

4.16. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж ажиллахдаа тухайн даатгалын байгууллага болон түүнтэй холбоотой даатгуулагч иргэд, байгууллагуудын санал хүсэлт, өргөдөл, гомдол зэргийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу шийдвэрлэх тухай саналаа боловсруулж, Даатгалын газрын даргад тухайн бүрд танилцуулж байна.

4.17. Мэргэжилтэн нь даатгалын байгууллагаас сар бүрийн сүүлийн өдрийн байдлаар ирүүлсэн мэдээ, улирал бүр ирүүлсэн санхүүгийн тайланг хянаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тайлант хугацааны дараа сарын 20-ны өдрийн дотор илэрсэн алдаа, зөрчлийн талаар дэлгэрэнгүй тусгасан тайлангийн хариуг даатгалын байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

4.18. Даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн даатгалын салбарын нэгдсэн танилцуулгыг улирал бүрийн дараа сарын 25-ны өдрийн дотор бэлэн болгож, Даатгалын газрын даргад танилцуулна.

4.19. Даатгалын газрын дарга нь даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтний боловсруулсан даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүдийн нэгтгэл, нэгдсэн танилцуулгыг хянасны дагуу гарын үсэг зурж баталгаажуулна.

4.20. Даатгалын салбарын улирал бүрийн санхүүгийн тайлан, мэдээний нэгтгэлийг танилцуулгын хамт улирлын дараа сард багтаан Хорооны удирдлагад хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллана.

4.21. Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг Хорооны удирдлагад тухайн бүрд танилцуулна.

4.22. Даатгалын салбарын тайлант оны нэгтгэлийг дараа оны эхний улирлын сүүлийн өдрийн дотор УИХ, Сангийн яам, Монголбанк болон шаардлагатай бусад байгууллагад Хорооны тайлангийн хамтаар хүргүүлнэ.

### **ТАВ. Хяналтын мөрөөр авах арга хэмжээ**

#### *Тайлан, мэдээнд тавих хяналтын мөрөөр авах арга хэмжээ*

5.1. Даатгалын байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээ нь хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй буюу даатгалын байгууллага цаг хугацаанд нь тайлан, мэдээгээ ирүүлээгүй бол тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан мэргэжилтэн дараах арга хэмжээг шат дараалан авна:

5.1.1. Тайлан, мэдээг ирүүлбэл зохих тогтоосон хугацаанаас хойш ажлын нэг хоногоор хоцорсон бол тэр даруй Хорооны бичиг хэргээс тухайн тайлан мэдээг шүүн шалгаж тодруулна.

5.1.2. Тайлан, мэдээг ирүүлээгүй нь тогтоогдвол тухайн даатгалын байгууллагын удирдлагад албан бичгээр яаралтай мэдэгдэж, нэн даруй ирүүлэхийг шаардана.

5.1.3. Тайлан, мэдээг цаг хугацаанд нь ирүүлээгүй зөрчлийг давтан гаргасан болон албан тоотгоор шаардсан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд Даатгалын тухай хуулийн 83.1.32 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1.14-т заасны дагуу хариуцлага ногдуулна.

5.1.4. Дээрх зөрчлийг давтан гаргасан, шаардсаар байтал тайлан, мэдээг ирүүлээгүй тохиолдолд улсын байцаагчийн акт тогтоон дараагийн шатны арга хэмжээг авч, Хорооны удирдлагад танилцуулна.

5.1.5. Хэрэв даатгалын байгууллага хууль тогтоомжид зааснаас өөрөөр эсвэл тэдгээрт заасан шаардлагыг хангаагүй тайлан мэдээ ирүүлсэн

бол тухайн даатгалын байгууллагын удирдлагад албан бичгээр мэдэгдэж, шаардлага хангасан тайлан, мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардана.

5.1.6. Даатгалын байгууллагын санхүүгийн тайлан, бусад тайлан, мэдээг алдаатай, холбогдох хууль тогтоомж болон даатгалын дүрэм, журмын дагуу гаргаж ирүүлээгүй зөрчлийг давтан гаргасан бол даатгалын байгууллагын удирдлагад мэдэгдэж, Даатгалын тухай хуулийн 83.1.10 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1.4-т заасны дагуу хариуцлага ногдуулна.

Албадлагын арга хэмжээ авах

5.2. Даатгалын холбогдох хууль тогтоомж болон Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан аливаа шийдвэрийг зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан, Хорооны улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулахад мөрдөх холбогдох журмын дагуу Хорооны албадлагын арга хэмжээг авч, захиргааны шийтгэл ногдуулна. Даатгалын байгууллагад арга хэмжээ авч, захиргааны шийтгэл ногдуулахаас гадна гаргасан зөрчлийн цар хүрээ, үр дагаварын байдлаас хамааруулан дараах арга хэмжээний аль нэгийг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

5.2.1. Даатгалын байгууллагын удирдлагатай уулзаж анхааруулах;

5.2.2. Газар дээр сэдэвчилсэн шалгалт хийх;

5.2.3. Хугацаатай үүрэг даалгавар өгөх;

5.2.4. Даатгалын тухай хуулийн 83.1 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу хариуцлага ногдуулах.

5.3. Даатгалын багц дүрмийг бүрэн биелүүлж ажиллаагүй хөнгөн маягийн зөрчил анх удаа гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахыг Хорооны албан бичгээр сануулна.

5.4. Даатгалын байгууллагын гаргасан зөрчил, дутагдал нь ноцтой буюу өмнөх зөрчил дутагдлыг дахин давтсан, энэ нь тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл мэргэжилтэн нь тухайн даатгалын байгууллагын талаар танилцуулга, урьдчилсан хяналтын дүгнэлтийн хамтаар боловсруулж, Даатгалын газрын даргаар уламжлан Хорооны удирдлагад танилцуулна. Танилцуулгад дараах асуудлуудын талаар тодорхой тусгасан байна. Үүнд:

5.4.1. Тухайн даатгалын байгууллага нь хууль тогтоомжийг ямар хугацаагаар, хэдэн удаа зөрчсөн;

5.4.2. Уг зөрчилтэй холбогдуулан тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагааг шалгасан мэргэжилтнээс авсан арга хэмжээний дэлгэрэнгүй жагсаалт;

5.4.3. Уг зөрчил, дутагдал нь тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлсөн, цаашид ямар байдлаар нөлөөлөх;

5.4.4. Илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээний талаар тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьсан мэргэжилтний боловсруулсан санал.

5.5. Илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний саналд даатгалын байгууллагын тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хязгаарлах, зогсоох, эсхүл Даатгалын тухай хуулийн 83.1 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1-д тус тус заасны дагуу хариуцлага ногдуулах талаар тусгана.

5.6. Мэргэжилтэн нь санхүү, төлбөрийн чадварын хүндрэлд орсон даатгалын байгууллагад албадлагын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл холбогдох акт, албан тоот, тушаалын төслүүдийг дүгнэлтийн хамтаар Даатгалын газрын даргад танилцуулна.

5.7. Даатгалын газрын дарга танилцуулгыг хянаж, өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзвэл холбогдох арга хэмжээг авна. Хэрэв эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжгүй болон үүссэн асуудлыг ноцтой гэж үзсэн тохиолдолд нэмж тодруулах шаардлагатай зүйлийг тодруулсны үндсэн дээр Хорооны удирдлагад танилцуулна.

5.8. Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг ноцтой гэж үзсэн тохиолдолд Хорооны удирдлагад танилцуулсны үндсэн дээр Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулна.

## **ЗУРГАА. Хариуцлага**

6.1. Мэргэжилтэн нь тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас тавьсан хяналтын дүгнэлт, түүний үнэн зөв болон цаг хугацаандаа хийгдсэн эсэх талаар, даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн нь даатгалын салбарын санхүүгийн нэгдсэн үзүүлэлтүүдийн үнэн зөв, алдаагүй байдал болон цаг хугацаандаа хийгдсэн талаар, Даатгалын газрын дарга нь дүгнэлтийн талаарх эцсийн хариуцлагыг тус тус хүлээнэ.

6.2. Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж ажилласан мэргэжилтэн нь зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийг буруу хийснээс үүдэн даатгалын салбарын нэгтгэл, түүнд хийсэн дүгнэлт буруу гарсан тохиолдолд даатгалын салбарын нэгтгэл хариуцсан мэргэжилтэн хариуцлага хүлээхгүй.



6.3. Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж, дүгнэлт гаргахдаа санаатай буюу санамсаргүй байдлаар алдаа гаргасан бол мэргэжилтэн нь Хорооны улсын байцаагчийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Хэрэв даатгалын байгууллага болон холбогдох хуулийн этгээд, түүний эрх бүхий ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн шаардлагатай тайлан, мэдээ, судалгааг хугацаанд нь гаргаж ирүүлээгүйгээс үүсэх аливаа асуудалд мэргэжилтэн хариуцлага хүлээхгүй.

-ooOoo--

Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журмын 1 дүгээр хавсралт

## ДҮРМИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ

Даатгалын байгууллагын дүрмийн сангийн бүрдэлт, байршилт нь тавьсан нөхцөл шаардлагад хэрхэн нийцэж байгааг Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөцийн сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын дагуу хянаж, үнэлэлт дүгнэлт өгнө.

Даатгалын байгууллагын дүрмийн сангийн бүрдэлт, байршилт

№	Хөрөнгө оруулсан иргэн, байгууллагын нэр	Оруулсан хөрөнгийн хэмжээ ... оны эцсийн байдлаар		(мянган төгрөг) Хөрөнгийн байршилт (банкны нэр, дансны дугаар)
		Дүн	Эзлэх хувь	
1				
2				

Дүн

Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт  
тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журмын 2 дугаар хавсралт

## МӨНГӨН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛТ

Даатгалын байгууллагын мөнгөн хөрөнгийн байршилтыг дараах байдлаар  
ангилж харуулна. Үүнд:

1. харилцах дансанд;
2. кассанд;
3. хадгаламжийн дансанд;
4. бусад.

Даатгалын байгууллагын дүрмийн сан болон даатгалын учирч болзошгүй  
хохирлын нөөц санг мөнгөн хөрөнгийн хэлбэрээр байршуулсан байдал

	(мянган төгрөг)			
Үзүүлэлт	200...3.31	200...6.30	200...9.30	200...12.31
Харилцах дансанд				
Кассанд				
Хадгаламжинд				
Бусад				
Бэлэн хөрөнгийн нийт дүн				
Байх хөрөнгийн дүн				
Бэлэн болон байх хөрөнгийн харьцаа хувиар				

Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журмын 3 дугаар хавсралт

## ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Даатгалын байгууллагын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг Хорооны 2007 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын дагуу даатгалын компанид байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээгээр тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгнө.

Даатгалын байгууллагад байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээ нь орлогод тооцсон хураамжийн 150 хувиас багагүй байх бөгөөд дараах байдлаар тооцно:

A=B-B-Г

Үүнд: А - Даатгалын компанид байвал зохих хөрөнгийн хамгийн бага хэмжээ;  
Б - Нийт хөрөнгө;  
В - Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө;  
Г - Тохиргоо хийгдсэн хөрөнгийн дүн.

Зөвшөөрөгдөхгүй хөрөнгөд биет бус хөрөнгө, бараа материал, урьдчилж төлсөн зардал (тооцоо), 180 хоногоос дээш хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага орно.

Тохиргоо хийгдсэн хөрөнгөд доорхи хувиар бууруулж тооцсон хөрөнгө орно:

1. Бэлэн мөнгө, банкны харилцах дансанд байгаа мөнгө, Засгийн газрын өрийн бичиг, Төв банкны үнэт цаас 0%
2. Банкны хадгаламж, хадгаламжийн сертификат 2%
3. Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг 5%
4. Үл хөдлөх хөрөнгө 5%
5. Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 8%
6. Орон нутгийн засаг захиргааны бонд 10%
7. Компанийн бонд 10%
8. 180 хоногоос доош хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага 20%
9. Эд хогшил, тоног төхөөрөмж 20%
10. Зээл 20%

Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журмын 4 дүгээр хавсралт

## ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны тайлан, даатгалын үндсэн үйл ажиллагааны орлого, зарлага, ашиг (алдагдал), үндсэн үйл ажиллагааны бус орлого, зарлага, ашиг (алдагдал), үүнд нөлөөлсөн хүчин зүйлс, өмнөх оноос өссөн, буурсан байдлын талаарх мэдээллийг тоо, баримттайгаар судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Үүнд:

1. даатгалын хураамжийн нийт орлого;
2. даатгалын нөхөн төлбөрийн олголт;
3. даатгалын учирч болзошгүй хохирлын нөөц сан;
4. нийт зардал;
5. ашиг (алдагдал);
6. санхүүгийн бусад мэдээлэл.

Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөг)

№	Үзүүлэлт	200... оны ... дугаар сарын ...-ны өдрийн байдлаар
1	Хураамжийн нийт орлого	
2	Давхар даатгалд төлсөн хураамж	
3	Даатгалын цэвэр хураамж	
4	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	
5	Орлогод тооцсон хураамж	
6	Хохиролд олгосон нөхөн төлбөр	
7	Байгуулсан нөөцийн сан	
8	Үндсэн үйл ажиллагааны зардал	
9	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	
10	Үндсэн үйл ажиллагааны бус орлого	
11	Үндсэн үйл ажиллагааны бус зарлага	
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	
13	Орлогын албан татвар	
14	Цэвэр ашиг (алдагдал)	

Хяналтын хамрах хугацаанд даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны улмаас үүссэн өглөг, авлага, үндсэн хөрөнгө бэлдсэн байдал, мөн тэдгээрийн өсөлт, бууралтын талаарх мэдээллийг судлан үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Үүнд:

1. нийт өр төлбөр, богино болон урт хугацаат өглөг;
2. авлага;
3. үндсэн хөрөнгө, бараа материалын дүн;

4. өглөг, авлагын өөрчлөлтийн талаарх мэдээлэл (үүнд нөлөөлсөн хүчин зүйлс);
5. өр төлбөрийн улмаас үүсч болзошгүй санхүүгийн эрсдэл, бусад үр дагавар.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	(мянган төгрөг) 200... оны ... дугаар сарын ...-ны өдрийн бадлаар
1	Мөнгөн хөрөнгө	
2	Авлага	
3	Бараа материал	
4	Үндсэн хөрөнгө	
5	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	
6	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	
7	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	
8	Богино хугацаат өглөг	
9	Эзэмшигчдийн өмч	
10	Ашиг (алдагдал)	
11	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	

Даатгалын байгууллага учирч болзошгүй хохирлын нөөц санг бүрдүүлэхдээ Хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажилласан байдал болон даатгалын нөөц сангийн зарцуулалтын талаарх мэдээллийг судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Үүнд:

1. даатгалын нөөц сангийн бүрдэлтийн үнэн зөв байдал;
2. батлагдсан журмын дагуу даатгалын хэлбэр тус бүрээр учирч болзошгүй хохирлын нөөц санг байгуулсан эсэх;
3. дансанд байгаа нөөц сангийн үлдэгдэл бүрдүүлсэн байвал зохих нөөц сангийн тооцоолсон дүнтэй таарч байгаа эсэх (хэрэв зөрж байвал яагаад, ямар хэмжээгээр зөрсөн, юуны учраас гэдгийг тайлбарлах);
4. даатгалын орлогод тооцсон хураамж, даатгалын нөхөн төлбөрийн харьцаа.

Даатгалын байгууллагын нөөцийн сангийн бүрдэлт, зарцуулалт

(мянган төгрөг)

№	Үзүүлэлт	200... он
1	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн эхний үлдэгдэл	
2	Учирч болзошгүй хохирлын нөөц сангаас олгосон нөхөн төлбөр	
3	Орлогод тооцсон хураамж	
4	Орлогод тооцсон хураамжаас олгосон хохирлын нөхөн төлбөр	

- 5 Байгуулсан (нэмэгдсэн) нөөц сан
- 6 Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн эцсийн үлдэгдэл
- 7 Орлогод тооцсон хураамж, хохирлын нөхөн төлбөрийн харьцаа

--ooOoo--